



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

20 18 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 127

Алтай хот

“Эрүүл мэндийн байгууллагуудад ажилтан сонгон шалгаруулж авах нийтлэг журам батлах тухай

Монгол улсын “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дүгээр заалт, Засгийн газрын 2009 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 143 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1.Байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор “Эрүүл мэндийн байгууллагуудад ажилтан сонгон шалгаруулж авах нийтлэг журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон шаардлагатай арга хэмжээг авч, сонгон шалгаруулах үеийн шалгалтын сорилгыг боловсруулан батлуулахыг харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга /С.Цогзолмаа/, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн /О.Мягмарбодь/ нарт даалгасугай.

ДАРГА  Ц.ТУЯА

ДИСЧЕВЕР 1014869

Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны
07 дугаар сарын 04-ны өдрийн А/28 дугаар
тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АЖИЛТАН СОНГОН
ШАЛГАРУУЛЖ АВАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг.Зорилго

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй, шуурхай, хэвийн үйл ажиллагаа, ил тод, шударга байдлыг хангах, ажил албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулж, ажлын байрны шаардлагад нийцсэн хүний нөөцийг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Журмын хамрах хүрээ

2.1. Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.12, 15.16, 15.1.7, 15.1.12 дах заалтад заасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагууд /Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв/ -ын эрүүл мэндийн ажилтнууд /эмчлэгч эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, жолооч, үйлчлэгч, угаагч, галч зэрэг төрийн үйлчилгээний ангиллын ажлын байр/-ыг сонгон шалгаруулахад энэхүү журам үйлчилнэ.

2.2. Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирлаас бусад ажил албан тушаалд ажил хүссэн иргэнийг сонгон шалгаруулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2.3. Сонгон шалгаруулалтад байнгын болон түр ажлын байр, шинээр бий болсон ажлын байр хамаарна.

Гурав. Сонгон шалгаруулалтын удирдлага, зохион байгуулалт

3.1. Ажил хүссэн иргэнийг сонгон шалгаруулах ажлыг байгууллагын дарга, захирлын тушаалаар тухай бүр байгуулсан Ажлын хэсэг эрхлэн гүйцэтгэнэ.

3.2. Ажлын хэсгийг тухайн ажлын байрны чиг үүрэг, онцлогтой уялдуулан 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

3.3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ашиг сонирхлын зөрчилгүйгээ бичгээр илэрхийлэх бөгөөд төрийн албан хаагчийн ёс зүйг чанд баримтлан, шударга, ил тод, тэгш хандах, нээлттэй, өрсөлдөөний зарчмыг удирдлага болгон ажиллана.

3.4. Сонгон шалгаруулалт явуулах ажил, албан тушаалын "Ажлын байрны тодорхойлолт"-ыг томилох эрх бүхий этгээд баталгаажуулж, түүнд нийцсэн иргэнийг бүртгэж, сонгон шалгаруулалтад оруулна.

3.5. Ажлын хэсгийн сонгон шалгаруулалт явуулахтай холбогдох зардал, шаардагдах нөхцлийг тухайн байгууллага бүрэн хангасан байна.

Дөрөв. Сул орон тооны захиалга ирүүлэх

4.1. Томилох эрх бүхий этгээд буюу эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нь байнгын болон түр ажлын байрны орон тоо гарсан, шинээр ажлын байр бий болсноос хойш 3 хоногийн дотор ажлын байрыг нөхөх, уг ажлын байрны сонгон шалгаруулах захиалгыг аймаг, сумын Хөдөлмөр эрхлэлтийн нэгж, Эрүүл мэндийн газарт ирүүлнэ.

Тав. Сонгон шалгаруулалтыг мэдээлэх

5.1. Ажлын байрны захиалгыг аймаг, сумын Хөдөлмөр эрхлэлтийн нэгж, Эрүүл мэндийн газрын бүртгэлд орсны дараа тухайн байгууллага ажлын байрыг нээлттэй зарлана.

5.2. Сонгон шалгаруулалтын зарыг ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, сум, байгууллага, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн вэб сайт, цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

5.3. Тухайн ажлын байрыг захиалсан байгууллага болон аймаг, сумын Хөдөлмөр эрхлэлтийн нэгж, Эрүүл мэндийн газарт өргөдөл, хүсэлт ирүүлсэн иргэдийн жагсаалтыг хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ажилтан гаргана.

5.4. Дээрх жагсаалтуудыг тухайн байгууллагын Ажлын хэсэг нэгтгэж, бүртгэгдсэн иргэдийг шалгаруулалтад хамруулна.

5.5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сайтад тавих зар мэдээнд ажлын байранд тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, холбогдох байгууллагын хаяг, утасны дугаар, материал хүлээн авах, бүртгэл явагдах хугацааг тодорхой заасан байна.

5.6. Зарлагдсан ажлын байрны хүрээ, бүртгэгдсэн иргэдийн тооноос хамаарч сонгон шалгаруулалт явуулах байр, хугацааг тусгайлан мэдээлнэ.

Зургаа. Сонгон шалгаруулалтын үе шат

6.1. Сонгон шалгаруулалтыг дараах үе шаттай зохион байгуулна.

6.1.1. Тухайн ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн материал бүрдүүлсэн ажил хүсэгчийг сонгох

6.1.2. Ерөнхий мэдлэгийн шалгалт сорилыг бичгээр

6.1.3. Ур чадварын шалгалтыг гардан үйлдэл болон кэйс ажиллуулна.

6.1.4. Харилцаа хандлагыг тодорхойлох шалгалтыг ярилцлага хэлбэрээр явуулна.

6.2. Тухайн ажлын байрны чиг үүрэг, онцлогоос хамааран ур чадварын шалгалтыг нэмэлтээр авч болно.

6.3. Сонгон шалгаруулалттай холбоотой тест, бичгийн болон ур чадварын даалгавар, ярилцлагын сэдэв нууцлалын зэрэгтэй байна.

6.4. Сонгон шалгаруулалтын даалгавар бүрийн дүнг оролцогчдод тухай бүр нээлттэй мэдээлнэ.

6.5. Дүнг нэгтгэн онооны дарааллаар байр эзлүүлсэн жагсаалт үйлдэж, томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

6.6. Сонгон шалгаруулалт зохион байгуулах явцын болон дүнгийн хурлын тэмдэглэл, шалгуулагчдын бүртгэл, шалгалтын дүнгийн нэгтгэл, тэнцсэн иргэдийн нөөцийн бүртгэл, холбогдох материалыг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу албажуулна.

6.7. Байгууллагын удирдлага нь тухайн сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг аймаг, сумын Хөдөлмөр эрхлэлтийн нэгж, Эрүүл мэндийн газарт ажлын 1 өдөрт багтаан албан бичгээр ирүүлж, сум, байгууллагын вэб сайтад байршуулна.

6.8. Сонгон шалгаруулалтанд тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн иргэдийн мэдээлэл нь байгууллагад хадгалагдах бөгөөд жилийн хугацаанд тухайн ажлын байр болон шаардлагатай тохиолдолд ижил төрлийн ажлын байрны нөөцөд хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.9. Тэнцсэн иргэн тухайн ажлын байранд ажиллахаас татгалзвал энэ тухай бичгээр мэдэгдсэний дараа нөөцөөс хасагдсанд тооцож, онооны дарааллыг баримтлан дараагийн иргэнийг томилно.

Долоо. Гомдол, маргааныг шийдвэрлэх

7.1. Сонгон шалгаруулалттай холбогдсон асуудлаар шалгуулагчаас гомдлыг бичгээр авах бөгөөд цаг тухайд нь Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуралдаж, бие даан шийдвэрлэнэ.

Найм. Ажлын хэсгийн хүлээх хариуцлага

8.1. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа Ажлын хэсгийн гишүүд энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын "Төрийн албаны тухай" хууль, "Хөдөлмөрийн тухай" хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.